

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
11-Р АНГИЙН ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ
ХУВИЛБАР А.**

..... ангийн сурагч

Хугацаа 80 минут

Авбал зохих оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
100		

XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ

- Өвөр Монгол хэзээ Манжид дагаар орсон бэ? **᠒ оноо**
 A. 1936 он B. 1691 он C. 1755 он D. 1688 он
- Зүүн гарын хаант улсыг 1671-1697 онд захирч байсан анхны хаан хэн бэ? **᠒ оноо**
 A. Галданцэрэн хаан B. Цэвээнравдан хаан
 C. Даваач хаан D. Галдан бошигт хаан
- Манжууд аль Монголчуудтай худ ургийн холбоог эхлэн тогтоож, өөртөө татах бодлого баримталж байсан бэ? **᠒ оноо**
 A. Халх Монгол B. Өвөр Монгол C. Зүүнгар улс D. Хошууд улс
- Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу. **᠒ оноо**
 A. Монголын их хааны сүр хүч суларч, монголчууд олон хэсэгт хуваагдсан
 B. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн
 C. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн
 D. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж.
- Хэн Өвөр Монголын аймгууд Манжийн эрхшээлд орсон онуудыг зөв харгалзуулна уу? **᠔ оноо**
 A. 1626 он 1. Авга, Түмэд
 B. 1627 он 2. Найман, Аохан
 C. 1628 он 3. Жарууд, Баарин
 D. 1629 он 4. Харчин
 A. A1, B2, C3, D4 B. A3, B2, C4, D3 C. A4, B3, C1, D2 D. A3, B1, C4, D2
- 1691 онд Халх Монголын ноёд, тайж нар, Өвөр Монголын 49 хошууны ноёдууд чуулжээ. **᠒ оноо**
 A. Мүгдэнд B. Ар Элстэйд C. Долоон нуурт D. Хөх нуурт
- Дараах сурвалжийг нэрлэнэ үү? **᠒ оноо**

“Манжийн жанжин, цэргүүд Зүүнгар улсын хүнийг хүртэл юуртэл хядан алж орон нутаг нь эзэнгүй хоосон болж, Улс иргэн нь хамтаар бүр мөсөн сөнөжээ. Галдан бошигт ханаас эхлэн эцсийн Амарсанаа ханд хүртэл Зүүн гар улсын бүх хүнийг зуугаар бодвоос дайнд автсан нь 30%, Дайчин улсад дагаар орж аймаг, хошуу, сум болсон нь 15%, айл зэргэлдээ улс аймагт зайлан гарч олзлогдсон нь 15% болох мэт бөгөөд газар нутаг нь тийнхүү хоосон болжээ”

- Лувсанданзан. “Алтан товч” зохиол
- Буянчулуун “ Дөрвөн Өөлдийн түүх” зохиол
- Монголын нууц товчоо
- “Хорийн болон Ага буриадын урьд цагийн түүх” зохиол

8. Манжийн эрхшээлийн үед Монголын нийгмийн дээд давхаргад ямар хүмүүс ордог байсан бэ? \2 оноо\
- A. хамжлага B. шавь C. албат ард D. тайж
9. Монголын хаант улсуудын үеийн түүхэн зүтгэлтнүүдийг хамаарах ойлголттой нь зөв харгалзуулна уу? \4 оноо\
- A. Лигдэн хаан 1. Цорос аймгийн толгойлогч
 B. Гомбодорж 2. Түшээт хан аймгийн удирдагч
 C. Шолой 3. Алтан ургийн сүүлчийн хаан
 D. Эрдэнэбаатар хунтай 4. Сэцэн хан аймгийн удирдагч

МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ

10. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхэн ач холбогдол аль нь вэ? \2 оноо\
- A. Манжийн хуулийг дагаж мөрдөхөө больсон
 B. Манжийн амбан сайдыг хөөн гаргасан
 C. Манжийн алба татвараас чөлөөлөгдсөн
 D. Манжийн эрхшээлээс гарч, тусгаар тогтнолоо сэргээсэн
11. Хужирбуланд цэргийн сургууль хэдэн онд байгуулагдсан бэ? \2 оноо\
- A. 1912 он B. 1913 он C. 1914 он D. 1915 онд
12. 1913 онд “Монгол улсын хилийн хязгаар доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмаз, эрдэнийн чулууны орлогын хэдэн хувийг татварлах болсон бэ? \2 оноо\
- A. 30-60% B. 5-10% C. 20-50% D. 20-30%
13. 1921 оны 7 сарын 11-нд Богд хааныг хэмжээт эрхт хаанаар өргөмжилж, оны цолыг хэвээр хэрэглэж, “Ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг явуулах” болсныг олон түмэнд тунхаглан зарлажээ. Тэгвэл энэхүү 1921 он олноо өргөгдсөний хэддүгээр он болохыг тооцоолж зөв хариултыг сонгоно уу? \2 оноо\
- A. 1-р он B. 2-р он C. 10-р он D. 11-р он
14. 1921 оны 07 сарын 10-нд ямар түүхэн үйл явдал болсон бэ? \2 оноо\
- A. МАН-ыг байгуулсан B. Хиагтыг хятад цэргүүдээс чөлөөлсөн
 C. Ховдыг чөлөөлсөн D. Ардын засгийн газрыг байгуулсан
15. 1924 оны Үндсэн хуулиар улсын нэрийг хэрхэн өөрчилсөн бэ? \2 оноо\
- A. Олноо өргөгдсөн Монгол улс B. Автономит Монгол улс
 C. Бүгд Найрамдах Монгол Ард Улс D. Монгол улс
16. 1921 оны ардчилсан хувьсгалын үр дүнг тодорхойлж зөв хариултыг сонгоно уу? \2 оноо\
- A. Бүх Монгол овогтноо нэгтгэх боломж бүрдсэн
 B. Монгол үндэстэн сэргэн мандах эхлэл тавигдсан.
 C. Монголчууд манжийн эрхшээлээс гарч тусгаар тогтнолоо сэргээсэн
 D. Монгол улс тусгаар тогтнолоо дахин олж авсан
17. Монгол улсын хөгжлийн талаар С. Данзангийн үзэл баримтлал аль нь вэ? \2 оноо\
- A. Монголд бүг найрамдах засаг тогтоох, хүн төрөлтний туулж ирсэн жам ёсны хөгжлийн дагуу, шат дараалан хөгжих ёстой
 B. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой
 C. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах
 D. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих

18. 1911 оны хувьсгалд холбогдох түүхэн зүтгэлтнүүдийн түүхэн зургуудыг нэрлэж, доор бичнэ үү. **᠕4 оноо**

			
.....

19. Зүүн хүрээний бүлгэмийн гишүүдээс 4-ийг нэрлэж бичээрэй **᠕4 оноо**

- A. B.
C. D.

20. Богдын Засгийн газрын бүтцийг тодорхойлон бичнэ үү? **᠕4 оноо**

Богдийн засгийн газар

БНМАУ СОЦИАЛИЗМЫН ЗАМААР

21. Зурагт өгөгдсөн түүхэн үйл явдалд тохирох нэрийг олж дугуйлна уу? **᠕2 оноо**



- A. Богдыг хаан ширээнд өргөмжлөх ёслол
B. Анхдугаар Үндсэн хууль батлах үе
C. Чинээлэг ардын хөрөнгийг хураах үе
D. Зэвсэгт бослогод оролцогчдын хэргийг шүүх хурлын үе

22. 1935 онд хүн амын 5.6 хувь нь бичиг үсэгтэй байсан бол 1940 онд хэдэн хувь болж нэмэгдсэн бэ? **᠕2 оноо**

- A. 30.8% B. 40.1% C. 15.7% D. 39.1% E. 20.8%

23. Дэлхийн II дайн ямар үйл явдлаар дууссан бэ? **᠕2 оноо**

- A. 1945 оны 9 сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурсан
B. 1945 оны 5 сарын 9-нд нацист Герман бууж өгсөн
C. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ, Японд дайн зарласан
D. 1945 оны 8 сарын 10-нд БНМАУ Японд дайн зарласан

24. Атарын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ? **᠕2 оноо**

- A. 2008 он B. 1982 он C. 1976 он D. 1961 он E. 1959 он

25. 1936 оны 3 сарын 12-нд БНМАУ, ЗСБНУ-ын хооронд “Харилцан туслалцах Протокол”-ыг Улаанбаатар хотноо байгуулжээ. Уг “Протокол”-ын гол агуулга аль нь вэ? **᠕2 оноо**

- A. Хоёр улсын хилийг шинээр тогтоох
B. Эдийн засгийн салбарт хамтран ажиллах

- C. Японд довтолж түүний түрэмгийллийг зогсоох
- D. Гурав дахь этгээд хэн нэгэнд нь халдан довтолбол харилцан туслалцах
- E. Хоёр улс хамтран Хятадын эсрэг довтолох

26. Монгол улс хэзээ НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болсон бэ? **᠒ оноо**
 A. 1924 он B. 1940 он C. 1946 он D. 1961 он

27. Өгөгдөлд тулгуурлан “Монгол нутгийн захиргааны дүрэм”-ийг баталж аймгуудын нэрсийг өөрчлөхдөө баримталсан оновчтой шалгуур аль нь вэ? **᠒ оноо**

1. **1923 оноос өмнө:** Засагт хан, Сайн ноён хан, Түшээт хан, Сэцэн хан аймаг
2. **1923 оноос хойш:** Хантайшир, Цэцэрлэг мандал, Богд хан, Хэнтий уулын аймаг

- A. Уул усны нэрээр нэрлэгдэж байсан аймгуудыг засаг ноёдын нэрээр нэрлэх болжээ.
- B. Засаг ноёдын нэрээр нэрлэгдэж байсан аймгуудыг уул усны нэрээр нэрлэх болжээ.
- C. Засаг ноёдын нэрээр нэрлэгдэж байсан аймгуудыг ядуу ардын нэрээр нэрлэх болжээ.
- D. Уул усны нэрээр нэрлэгдэж байсан аймгуудыг ядуу ардын нэрээр нэрлэх болжээ.

28. БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухааны салбарт гарсан өөрчлөлтийг зөв харгалзуулна уу? **᠒ оноо**

- | | |
|------------|---|
| A. 1960 он | 1. Мандухай сэцэн хатан киног бүтээв |
| B. 1970 он | 2. Монгол хүн сансарт нисэв |
| C. 1981 он | 3. Хүн амын 89.3 хувь нь бичиг үсэг тайлавгдав |
| D. 1988 он | 4. ЕБС-ийн хөтөлбөрт биеийн тамирын хичээл үзэх шийдвэр гарав |

МОНГОЛ УЛС АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАМААР

29. Монголын ардчилсан холбооны анхны улс төрийн цуглаан хэзээ болсон бэ? **᠒ оноо**
 A. 1989.12.07 B. 1990.02.18 C. 1990.01.21 D. 1989.12.10

30. 2012 оноос өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдрийг ямар тэмдэглэлт баярын өдөр болгосон бэ? **᠒ оноо**

- | | |
|---|--------------------------------|
| A. Олон улсын хүний эрхийн өдөр | B. Эх орончдын өдөр |
| C. Монгол бахархлын өдөр | D. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр |
| E. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр | |

31. 1992 оны шинэ Үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдлийг төрийн ямар байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан бэ? **᠒ оноо**

- | | |
|--------------------|---------------------|
| A. Улсын Дээд шүүх | B. Улсын бага хурал |
| C. Улсын Их хурал | D. Ардын Их хурал |

32. 1990 оны ардчилсан хувьсгал гарахад нөлөөлсөн гадаад шалтгааныг тодорхойлно уу? **᠒ оноо**

- A. ЗХУ-аас эдийн засгийн тусламж, дэмжлэгийг авахын тулд
- B. ЗХУ-ын улс төр, цэргийн хүч нөлөө буурсныг ашигласан
- C. Социалист системийн хямрал, задрал
- D. Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүн орон болохын тулд

33. Мэгжид Жанрайсаг шүтээн бүтээн залах ажлыг Ерөнхийлөгчийн зарлигаар гүйцэтгэж, хэдэн оны намар Гандантэгчинлэн хийдэд залсан бэ? **᠒ оноо**

- | | | | | |
|------------|------------|------------|------------|------------|
| A. 1996 он | B. 1998 он | C. 2000 он | D. 2004 он | E. 2007 он |
|------------|------------|------------|------------|------------|

34. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? **᠒ оноо**

- A. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав
- B. Японы ерөнхий сайд Тошкү Кайфу айлчлав
- C. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав

- D. НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга К. Аннан айлчлав
- E. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал анх удаа батлагдав.


35. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг илэрхийлэх баримт аль вэ? \2 оноо\

- A. 1990 онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн.
- B. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” баталсан
- C. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан
- D. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн

36. Монголын төр 1996 онд ард түмнээсээ уучлал гуйж, 9 сарын 10-ыг ямар тэмдэглэлт өдөр болгосон бэ? \2 оноо\

- A. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр
- B. Монгол бахархлын өдөр
- C. Эх орончдын өдөр
- D. Олон улсын хүний эрхийн өдөр

37. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү \2 оноо\



- A. Монголд анх удаа чөлөөт ардчилсан сонгууль явагдав. Өмч хувьчлал эхлэв.
- B. МоАХ байгуулагдав. Шинэ Үндсэн хуулийг батлав.
- C. Газрын тухай хууль батлав. Хэвлэлийн мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлав.
- D. Бурхан багшийн чандрыг Монголд залав. “Монгол Улсын Түүх” 5 боть бүтээл гаргав

38. Дараах зурагт нэр өгч, 1 өгүүлбэрт багтааж бичээрэй. \4 оноо\



.....

.....

.....

.....

39. Ардчилсан хувьсгал өрнөснөөр болсон түүхэн үйл явдлуудыг холбогдох он цагтай нь зөв харгалзуулна уу? \4 оноо\

- | | |
|------------|---|
| A. 1989 он | 1. Шинэ үндсэн хууль батлагдав. |
| B. 1990 он | 2. Монголын ардчилсан холбоо байгуулагдав |
| C. 1991 он | 3. Өмч хувьчлал эхлэв. |
| D. 1992 он | 4. Монголд анх удаа чөлөөт ардчилсан сонгууль явагдав |

40. Ардчилсан хувьсгалын үр дүнд ямар өөрчлөлт тодорхойлж тохирох хэсэгтэй нь холбоно уу? \4 оноо\

- | | |
|-------------------------|---|
| A. Үндсэн хуулийн цэц | 1. Их хувьчлалын 7000 төгрөгтэй дүйх бичиг |
| B. Цэнхэр тасалбар | 2. Чөлөөт үнийн тогтолцоонд шилжсэн шийдвэр |
| C. ЗГ-ын 20-р тогтоол | 3. 5 боть суурь бүтээл хэвлэгдэв |
| D. Монголын нууц товчоо | 4. Ардчилсан, хууль ёсыг хамгаалах дээд байгууллага |
| E. Монгол улсын түүх | 5. 750 жилийн ойг тэмдэглэв |

Түлхүүр
Хувилбар А

Даалгавар	Зөв хариулт	оноо
1	A	2
2	D	2
3	B	2
4	A	2
5	B	4
6	C	2
7	B	2
8	D	2
9	a3,b2,c4,d1	4
10	D	2
11	A	2
12	C	2
13	D	2
14	D	2
15	C	2
16	B	2
17	A	2
18	Жавзандамба, Намнансүрэн, Ханддорж, Цэрэнчимэд	4
19	М. Дугаржав, Д. Сүхбаатар, Галсан, Тогтох	4
20	Богд хаан, Ерөнхий сайд, Улсын дээд, доод хурал, бүгдийг ерөнхийлөн захирах яам, шашин төрд туслах сайдын яам	4
21	C	2
22	E	2
23	A	2
24	E	2
25	D	2
26	D	2
27	B	4
28	a4,b3,c2,d1	4
29	D	2
30	C	2
31	C	2
32	C	2
33	A	2
34	A	2
35	A	2
36	A	2
37	B	2
38	Улс төрийн анхны цуглаан, Залуучуудын соёлын төв 1989.12.10	4
39	A2,B4,C3,D1	4
40	A4,B1,C2,D5,E3	4

100

